

Сэжигтний овог нэр: _____

さま
様

Сэжигтний тэмдэглэл

(Мэдүүлэг өгсөн тэмдэглэл)

ひぎしゃ とりしら きろく
被疑者ノート 取調べの記録

(_____ оны _____ сарын _____ өдрөөс — _____ оны _____ сарын _____ өдөр хүртэл)

(_____ 年 _____ 月 _____ 日 から _____ 年 _____ 月 _____ 日まで)

_____ он _____ сар _____ өдөр
年 月 日

Өмгөөлөгч:

べんごし
弁護士

Тус тэмдэглэлд өөрийн мэдүүлэг өгсөн байдлын талаар тэмдэглэн дараа өдөр өмгөөлөгчид буцааж өгнө үү.

このノートに、あなたが受けた取調べの様子を記録して、後日、私に返してください。

警察・検察の方へ

このノートは、弁護人が、接見の際に見ながら取調べ状況の説明を受けるとともに、後日返却を受け、弁護活動に役立てることを予定して、被疑者に差し入れ、記録を要請するものですので、その記録内容については、憲法に由来する秘密交通権の保障を受けます。

Цагдаа, прокурорын ажилтнуудад

Тус тэмдэглэлийг өмгөөлөгч сэжигтэнтэй ганцаарчлан уулзах үед бичигдсэн агуулгад үндэслэн мэдүүлэг өгсөн байдлын талаар тайлбар сонсох, өмгөөллийн үйл ажиллагаанд ашиглахын тулд дараа өдөр түр буцааж авах, сэжигтэнд эргүүлж өгөн тэмдэглэл хөтлүүлэх зэрэг зорилгоор хэрэглэнэ. Мөн тус тэмдэглэлд бичигдсэн зүйлсийн агуулга нь үндсэн хуулийн заалтад үндэслэсэн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах болон бичиг баримт, эд зүйлс солилцох харилцааны нууцлалын эрхийн дагуу хамгаалагдсан болно.

モンゴル語版

2012年12月版 Монгол орчуулга 2012 оны 12 сарын хэвлэл
Японы Өмгөөлөгчдийн Нэгдсэн Холбоо

JABA 日本弁護士連合会

Сэжигтний тэмдэглэл

Гарчиг

■ Баривчлан саатуулах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараалал.....	2
■ Мэдүүлэг өгөхтэй холбогдсон чухал зөвлөгөөнүүд Мэдүүлэг өгөхөөс өмнөх сэтгэл зүйн бэлтгэл	4
Өмнөх үг	4
Бүлэг 1. Цаашид хийгдэх хянан шийдвэрлэх ажиллагааны тухай	4
Бүлэг 2. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахын ач холбогдол.....	6
Бүлэг 3. Мэдүүлэг өгөхөөс өмнө урьдчилан анхаарах зүйлүүд.....	7
Бүлэг 4. “Сэжигтний тэмдэглэл”-ийг өдөр тутам хөтлөхийг зөвлөө “Сэжигтний тэмдэглэл” Танд тус болно	13
Бүлэг 5. “Сэжигтний тэмдэглэл”-ийг хэрхэн хөтлөх тухай.....	14
Бүлэг 6 “Сэжигтний тэмдэглэл”-ийг хэрхэн ашиглах тухай.....	15
Бүлэг 7. Хууль бус, зохисгүй байдлаар байцаалт авсан тохиолдолд яах вэ?.....	16
Төгсгөл Таны өөрийн тань сэтгэлийн тэвчээр хамгийн чухал.....	18
■ Мэдүүлэг өгсөн тэмдэглэл (Өдөр бүр бөглөж бичнэ үү)	20-65

Баривчлан саатуулах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараалал

Таныг баривчлан саатуулсанаас хойш явагдах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дарааллыг доор тайлбарласан тул уншиж танилцана уу. Мөн мэдүүлэг өгсөн, өмгөөлөгч болон бусад хүнтэй уулзсан уулзалтын талаар доорх хүснэгтийг бөглөж бичнэ үү.

Та баривчлагдан саатуулагдсан тохиолдолд эхлээд 72 цаг саатуулагдана. Энэ хугацаанд прокурор таныг үргэлжлүүлэн цагдан хорих ("цагдан хорих санал гаргах") эсэхийг шийднэ. Прокурор шүүгчид хандан цагдан хорих санал гаргавал шүүгч таны тайлбарыг ("цагдан хорих талаар сэжигтний тайлбарыг сонсох") сонссоны дараа үргэлжлүүлэн цагдан хорих зөвшөөрөл олгох эсэхийг шийднэ. Шүүгч цагдан хорих шаардлагагүй гэж үзвэл Та суллагдах болно.

Баривчлах	1 дэхь өдөр	/ ()	2 дахь өдөр	/ ()	3 дахь өдөр	/ ()
	<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй	
	<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()	
	<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)	
	<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)	
	<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()	
	Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()	

Цагдан хорих хугацаа нь үндсэн хугацаа 10 хоног боловч шүүгч сунгах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дахин 10 хүртэл хоногоор сунгахыг ("цагдан хорих хугацааг сунгах") зөвшөөрдөг. (Цагдан хорих хамгийн урт хугацаа 20 хоног байна)

→ Суллах

Цагдан хорих

1 дэхь өдөр	/ ()	2 дахь өдөр	/ ()	3 дахь өдөр	/ ()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй	
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()	
<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()	
Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()	

4 дэхь өдөр	/ ()	5 дахь өдөр	/ ()	6 дахь өдөр	/ ()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй	
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()	
<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()	
Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()	

7 дахь өдөр	/ ()	8 дахь өдөр	/ ()	9 дэхь өдөр	/ ()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй	
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()		<input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн ()	
<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)		<input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :)	
<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()		<input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн ()	
Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()		Авсан эд зүйл ()	

Цагдан хорих хугацааг
сунгах


10 дахь өдөр	/	()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			


1 дэхь өдөр	/	()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			

2 дахь өдөр	/	()	3 дахь өдөр	/	()	4 дэхь өдөр	/	()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()					

5 дахь өдөр	/	()	6 дахь өдөр	/	()	7 дахь өдөр	/	()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()					

8 дахь өдөр	/	()	9 дэхь өдөр	/	()	10 дахь өдөр	/	()
<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()			<input type="checkbox"/> Мэдүүлэг өгөөгүй <input type="checkbox"/> Мэдүүлэг өгсөн () <input type="checkbox"/> Өмгөөлөгчийн уулзалт (: - :) <input type="checkbox"/> Бусад уулзалт (: - :) <input type="checkbox"/> Эд зүйл авсан Өгсөн хүн () Авсан эд зүйл ()					





**Мэдүүлэг өгөхтэй холбогдсон
чухал зөвлөгөөнүүд
Мэдүүлэг өгөхөөс өмнөх сэтгэлзүйн бэлтгэл**

Өмнөх үг

Та баривчлагдаж, эсвэл баривчлагдан саатуулагдаагүй боловч өөрийн сайн дурын үндсэн дээр мэдүүлэг өгч байж болно. Ямар ч тохиолдолд байцаалтын хүнд нөхцөл байдалд мэдүүлэг өгөх үед байцаалтын тэмдэглэлд бичигдсэн агуулгыг өөрөө зөвшөөрөхгүй байгаа хэдий ч байцаагчийн хэлсэнээр “одоо зөвшөөрөөд гарын үсэг зурчихвал сэтгэл амар болох байх” гэсэн бодол Танд төрж болох юм. Гэхдээ Та байцаалтын тэмдэглэлд бичигдсэн агуулгыг зөвшөөрөхгүй байгаа атлаа сэтгэл санааны дарамтаас хурдан гарахын тулд яарч гарын үсэг зурсанаас болж дараа нь хүнд байдалд орох тохиолдол гарч болно.

Дараа нь тийм байдалд орж харамсахгүйн тулд мэдүүлэг өгөхөөс өмнө тус “Сэжигтний тэмдэглэл”-д бичигдсэн зөвлөгөөнүүдийг сайн уншиж танилцана уу.

Бүлэг 1. Цаашид хийгдэх хянан шийдвэрлэх ажиллагааны тухай

Баривчлах ажиллагаанаас хойш шүүх хурал дуусах хүртэлх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дараах дарааллаар явагдана. (2, 3-р хуудсанд бичигдсэн “Баривчлан саатуулах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараалал”-ыг уншина уу)

1. Баривчлагдах

Та цагдаад баривчлагдсан тохиолдолд цагдаагийн ажилтан Танаас 48 цагийн дотор мэдүүлэг авч хэргийг прокурорт шилжүүлнэ. Прокурор хэргийг хүлээж авснаас хойш 24 цагийн дотор Танаас урьдчилсан байцаалт авч, үргэлжлүүлэн саатуулах

шаардлагатай гэж үзвэл “цагдан хорих санал”-ыг шүүхэд гаргана. Харин прокурор цагдан хорих шаардлагагүй гэж үзвэл Та суллагдана.

2. Цагдан хоригдох

Прокурор шүүхэд хандан “цагдан хорих санал” гаргасан тохиолдолд шүүгч Таны тайлбарыг сонссоны дараа ("цагдан хорих талаар сэжигтний тайлбарыг сонсох") прокурорын цагдан хорих саналыг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэнэ.

Прокурорын гаргасан цагдан хорих саналыг шүүгч зөвшөөрсөн тохиолдолд прокурорын санал гарсан өдрөөс хойш 10 хоногийн хугацаагаар цагдан хоригдож Таны эрх чөлөө хязгаарлагдах болно. Улмаар энэ хугацаанд хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй тохиолдолд дахин 10 хүртэл хоногийн хугацаагаар хорих хугацааг сунгана.

Дээрх цагдан хоригдох хугацаанд цагдаагийн ажилтан болон прокурор Танаас байцаалт авч хэргийг шалгах болно. Харин шүүгч прокурорын цагдан хорих саналыг зөвшөөрөөгүй тохиолдолд Та суллагдах болно.

3. Хэргийг шүүхэд шилжүүлэх болон эс шилжүүлэх

Прокурор Танд холбогдох хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусмагц цагдан хоригдох хугацаанд багтааж хэргийг шүүхэд шилжүүлэх эсвэл шүүхэд шилжүүлэхгүй байх шийдвэрийн аль нэгийг гаргана. Прокурор хэргийг шүүхэд шилжүүлсэн тохиолдолд Танд холбогдох хэрэг шүүх хуралдаанаар шийдвэрлэгдэх болно.

◆ Барьцаагаар суллагдах

Прокурор хэргийг шүүхэд шилжүүлвэл ихэнх тохиолдолд үргэлжлэн цагдан хоригдох боловч шүүх "барьцаагаар суллах"-ыг зөвшөөрвөл шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд тодорхой заасан нөхцөл, хязгаарласан хүрээнд чөлөөтэй байх боломжтой болдог. Барьцаагаар суллах гэдэг нь шүүх (шүүгч) Таныг оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг устгах зэрэг үйлдэл хийхгүй гэж үзсэн, мөн барьцааны мөнгийг шүүхэд хадгалуулсан тохиолдолд нийгмийн амьдралд эргэж оролцохыг зөвшөөрдөг тогтолцоо юм.

Бүлэг 2. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахын ач холбогдол

1. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах нь хамгийн чухал Ямар нэг хүндрэл гарвал өмгөөлөгчөө дуудна уу

Байцаалтын явцад сэтгэл санааны зовиурт автан яахаа мэдэхгүй болох тохиолдол гардаг. Мөн байцаалтын тэмдэглэлд бичигдсэн агуулгыг Та зөвшөөрөхгүй байхад байцаагч гарын үсэг зурж, тамга дарахыг шаардах зэргээр хүнд байдалд оруулах явдал гардаг. Ийм тохиолдол гарвал Та гарын үсэг зурж тамга дарахаас өмнө өмгөөлөгчид хандаж зөвлөгөө аваарай. Та байцаагчийн хууль зөрчсөн болон зохисгүй нөхцөл байдалд мэдүүлэг өгсөн боловч түүний дарамт шахалтаас эмээн энэ талаар өмгөөлөгчид мэдэгдэж зөвлөгөө авахаас төвөгшөөх явдал гарч болох юм.

Гэвч чухам ийм үед л юуны өмнө өмгөөлөгчөө дуудан ирүүлж зөвлөгөө авах хэрэгтэй. (Мэдүүлэг өгөх үед анхаарах зүйлүүдийн талаар 3-аас 7-р бүлгийг уншиж танилцан, ойлгомжгүй зүйл байвал санаа зоволгүй өмгөөлөгчөөс асууж тодруулна уу.)

Хэрэв Та өмгөөлөгчтэй уулзаж зөвлөгөө авахыг хүсвэл байцаалт үргэлжилж байсан ч гэсэн байцаагчид хандан “өмгөөлөгчтэй яаралтай уулзах шаардлагатай байна” гэж хэлээд өмгөөлөгчөө дуудуулаарай. Сэжигтэн “өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хүсэлт” гаргасан үед нэн даруй өмгөөлөгчид нь мэдэгдэх тухай албан журам байдаг.

2. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах болон харилцааны нууцлалын эрх Өмгөөлөгчтэй ярилцсан агуулгын талаар мэдэгдэх шаардлагагүй

Байцаалтын явцад байцаагчийн зүгээс өмгөөлөгчтэй уулзах үед юу ярьсан, өмгөөлөгч ямар зөвлөгөө өгсөн гэх мэтээр асуух явдал байдаг. Байцаагч тэгж асуувал өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах үед ярилцсан зүйлийн талаар хэлэх ямар ч шаардлага байхгүй. Яагаад гэвэл өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах үед ярилцсан зүйлийн агуулга нь өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах болон харилцааны нууцлалын эрхийн дагуу хамгаалагдсан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39-р зүйлийн 1-д заасны дагуу энэ эрх мөн баталгаажсан болно.

3. “Сэжигтний тэмдэглэл”-ийг үзүүлэх шаардлагагүй

Тус тэмдэглэлийг өмгөөлөгч сэжигтэнтэй ганцаарчлан уулзах үед бичигдсэн зүйлийн агуулгад үндэслэн мэдүүлэг өгсөн байдлын талаар тайлбар сонсох, өмгөөллийн үйл ажиллагаанд ашиглахын тулд дараа өдөр түр буцааж авах, Танд эргүүлж өгөн тэмдэглэл хөтлүүлэх зорилготой бөгөөд Танд болон өмгөөлөгчид их чухал зүйл болно.

Хэрэв байцаагч тус “Сэжигтний тэмдэглэл”-д бичсэн агуулгыг үзүүлэхийг хүссэн ч Та өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах болон харилцааны нууцлалын эрхтэй учраас түүнд үзүүлэх ямар ч шаардлага байхгүй. Харин ч өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзсаны дараа мөрдөн шалгах байгууллагын зүгээс тэр талаар мэдээлэл өгөхийг шаардахыг хориглодог.

Мөн өөрийг тань зөвшөөрөхгүй байхад байцаагч тус тэмдэглэлийг үзэхийг оролдвол өмгөөлөгчид мэдэгдэж зөвлөгөө авна уу.

Бүлэг 3. Мэдүүлэг өгөхөөс өмнө урьдчилан анхаарах зүйлүүд

1. Тус “урьдчилан анхаарах зүйлүүд”-ийн талаар сайтар уншиж танилцана уу

Таныг баривчлан саатуулсаны дараа хэргийн талаар байцаалт явагдана. Байцаалтад хэрхэн хандахаас их зүйл шалтгаалах тул дараах “урьдчилан анхаарах зүйлүүд”-ийн талаарх зөвлөгөөг сайн уншина уу.

2. Та байцаалтын туршид дуугүй байж болно

Та мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй

Үндсэн хуулийн 38-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хэнийг ч өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгөхийг шаардахыг хориглоно” гэсэн заалтын дагуу Таны мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх баталгаажсан. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 198-р зүйлийн 2 дахь хэсэгт “Сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө өөрөө хүсэхгүй бол мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй болохыг урдчилан танилцуулна” гэж заасан тул Та байцаалтын туршид

дуугүй байх, эсвэл зөвхөн хариулахыг хүссэн асуултад хариулж, хариулахыг хүсээгүй асуултад хариулахаас татгалзаж болно.

Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх нь эрх мэдлээ буруугаар хэрэглэн гэм буруугүй хүнийг хуурамч мэдүүлэг өгөхийг шаардаж хэргийг хүчээр хүлээлгэдэг байсан сургамжаас үүдэж бий болсон. Орчин үеийн ямар ч төрт улсад хэн боловч мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээр хангагдсан байх ёстой.

Таныг асуултад хариулаагүй гэсэн үндэслэлээр буруутгаж болохгүй гэж хууль дүрэмд заасан байдаг тул энэ талаар санаа зовох хэрэггүй.

3. Юуны талаар асуулт хариулт явагдаж байгааг сайн ойлгох хэрэгтэй

Танаас авах мэдүүлгийг хэлмэрчээр дамжуулж авна. Хэлмэрчийн хэлж буй зүйлийг ойлгоогүй тохиолдолд түүнээс дахин сайн лавлаж асуух хэрэгтэй. Юуны талаар ярьж байгааг бүрэн ойлгохоос өмнө яарч хүлээн зөвшөөрч болохгүй гэдгийг сайтар анхаарах хэрэгтэй. Мөн Таны хэлсэнийг хэлмэрч сайн ойлгохгүй байвал түүнийг ойлготол нь дахин сайн тайлбарлаж өгөөрэй. Тэгсэн хэдий ч хэлмэрч Таны хэлсэнийг, эсвэл та хэлмэрчийн хэлсэнийг сайн ойлгохгүй байгаа бол мэдүүлэг өгөхөөс татгалзах хэрэгтэй.

4. Байцаагчийн дураараа зохиож бичсэн агуулгыг зөвшөөрч болохгүй

Таны зүгээс цагдаагийн ажилтан, эсвэл прокурорын өмнө хэлж мэдүүлсэн зүйлийг “мэдүүлэг” гэж хэлдэг бөгөөд Таны өгсөн мэдүүлэгт үндэслэн цагдаагийн ажилтан болон прокурор “байцаалтын тэмдэглэл” гэж нэрлэгдэх баримт бичгийг үйлдэнэ. Гэхдээ Таны хэлж мэдүүлсэн зүйл тэр байдлаараа байцаалтын тэмдэглэлд бичигдэхгүй бөгөөд байцаагч Таны хэлж мэдүүлсэн зүйлийг нэгтгэх байдлаар байцаалтын тэмдэглэлийг бичдэг. Үүнээс болж Таны хэлж ярьсан зүйл, байцаагчийн хувийн бодол хоёр хоорондоо холилдон аль хэсэг нь Таны хэлж ярьсан зүйл, аль хэсэг нь байцаагчийн бичсэн өгүүлбэр болохыг ялгаж салгах боломжгүй болдог. Япон улсын хуулиар өмгөөлөгчийг байлцуулан мэдүүлэг өгөхийг зөвшөөрөхгүйгээс гадна байцаалтын бүх явцыг дуу, дүрсний бүрэн бичлэг хийж баталгаажуулдаггүй тул

байцаалтын тэмдэглэлийн чухам аль хэсэг нь Таны хэлж ярьсан зүйл болохыг дараа нь шалгаж тодруулах аргагүй болно.

“Байцаалтын тэмдэглэл” нь хэргийн “нотлох баримт” болдог. “Байцаалтын тэмдэглэл” хэргийн “нотлох баримт”-аар зөвшөөрөгдөн шүүхэд шилжсэн тохиолдолд шүүхээс гарах шийдвэр нь Таны өгсөн “байцаалтын тэмдэглэл”-ийн агуулгаас шууд хамаарна гэж ойлгоорой. Та хэдийгээр шүүх хурал дээр “Байцаалтын тэмдэглэлд буруу бичигдсэн” гэж мэдүүлсэн ч шүүх Танд тийм амархан итгэхгүй.

Тийм учраас байцаагч байцаалтын тэмдэглэл үйлдэх үед маш их анхааралтай байх хэрэгтэй.

5. Байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, тамга дарах үүрэг Танд байхгүй

Гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзах эрх

Байцаалтын тэмдэглэлд заавал гарын үсэг зурж, тамга дарах тухай хуулиар хүлээсэн үүрэг Танд байхгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 198-р зүйлийн 5 дахь хэсэгт “Сэжигтэн байцаалтын тэмдэглэл алдаагүй бичигдсэн болохыг зөвшөөрсөн тохиолдолд татгалзахгүй бол гарын үсэг зуруулж тамга дарахыг шаардаж болно” гэж тодорхой заасан байна. Тийм болохоор Та байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзах эрхтэй.

Байцаалтын тэмдэглэл Таны хэлж мэдүүлсэний дагуу үнэн зөв бичигдсэн байсан ч гэсэн заавал гарын үсэг зурж тамга дарах үүрэг Танд байхгүй. Мөн байцаалтын тэмдэглэлд Таны хэлж мэдүүлээгүй зүйл бичигдсэн байвал гарын үсэг зурж, тамга дарах үүрэг хүлээхгүй болох нь бүр ч тодорхой.

Хэрэв Та Япон хэлээр уншиж чадахгүй бол байцаагч байцаалтын тэмдэглэлийг уншиж сонсон, хэлмэрч түүнийг хэлмэрчилсэний дараа үнэн зөв бичигдсэн эсэхийг Танаас тодруулж асууна. Гэхдээ хэлмэрч буруу хэлмэрчлэх, хэт хурдан ярих, эсвэл олон өдөр дараалж, удаан цагаар мэдүүлэг өгч та өөрөө хэт ядарсанаас болж андуурах, сонсохгүй өнгөрөх зэрэг тохиолдлууд гарч болзошгүй гэдгийг мартаж болохгүй.

Байцаалтын тэмдэглэлд бичигдсэн агуулга ойлгомжгүй, эсвэл хэлмэрчилсэн утга нь эргэлзээтэй санагдвал дахин унших болон хэлмэрчлэхийг хүсч, хэдэн удаа ч хамаагүй дахин анхааралтай сонсоорой.

Тэгсэн хэдий ч байцаалтын тэмдэглэлд бичигдсэн агуулгыг сайн ойлгохгүй бол өөрт оногдсон эрхийнхээ дагуу гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзаж болно.

6. Байцаалтын тэмдэглэлийг олон дахин шалгана уу

Байцаалтын тэмдэглэлийн агуулгыг яаралгүй сайн шалгаарай

Та байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж тамга дарсанаар бичигдсэн зүйл үнэн зөв гэдгийг хүлээн зөвшөөрсөн болно. Тийм учраас гарын үсэг зурж тамга дарахаас өмнө агуулгыг сайтар шалгах хэрэгтэй. Тэмдэглэлд бичигдсэн зүйл үнэн байдалтай таарахгүй байгааг мэдсээр байж гарын үсэг зурж тамга дарсаны дараа шүүх хурал дээр “Байцаалтын тэмдэглэлд бичигдсэн зүйл үнэн байдалтай таарахгүй байна” гэж мэдүүлсэн ч гэсэн шүүх Таны тайлбарыг хүлээн авахгүй байх тохиолдол байдаг тул сайтар анхаарах хэрэгтэй. Байцаалтын тэмдэглэлд бичигдсэн бага зэрэг утгын ялгаа нь шүүх хурал дээр их том ялгаа болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд байцаалтын тэмдэглэлийг бичиж дууссаны дараа бичигдсэн агуулгыг сэжигтнээр шалгуулахдаа, байцаагч байцаалтын тэмдэглэлийг сэжигтэнд уншиж сонсгох аргаар агуулгыг шалгуулж болно гэж заасан. Гэхдээ байцаагч хурдан унших, эсвэл та өөрөө их ядарсанаас болоод санамсаргүй байдлаар сонсохгүй өнгөрөх, андуурах зэрэг тохиолдлууд гардаг.

Та Япон хэлээр унших чадвартай байгаад байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж тамга дарахыг зөвшөөрч байгаа бол байцаагчид “Би өөрөө уншмаар байна” гэж хэлээд өөрөө сайн үзэж, бичигдсэн агуулгыг анхааралтай сайн уншаарай.

Хэрэв байцаагч Таны хүсэлтийг хүлээж авахгүй бол, Танд байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж тамга дарахаас татгалзах эрх байгаа учраас татгалзаж болно.

7. Бүрүү бичигдсэн байцаалтын тэмдэглэлд засвар оруулахыг хүсэх

Байцаалтын тэмдэглэлд засвар оруулж болно (Нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулахыг хүсэх эрх)

Та байцаалтын тэмдэглэлд засвар оруулахыг хүсэх эрхтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 198-р зүйлийн 4-р хэсэгт байцаагч байцаалтын тэмдэглэл үйлдсэний дараа “сэжигтэнд өөрт нь уншуулах эсвэл уншиж сонсон тэмдэглэл зөв бичигдсэн эсэхийг тодруулж, сэжигтэн өөрчлөлт оруулахыг хүсвэл тэр тухай

байцаалтын тэмдэглэлд заавал тэмдэглэнэ” гэж заасан (Байцаалтын тэмдэглэлд нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулахыг хүсэх эрх).

Та байцаалтын тэмдэглэлтэй уншиж танилцах үед бүхэлдээ үнэн зөв бичигдсэн боловч нэг л газар бага зэрэг алдаатай байсан ч гэсэн тухайн алдаатай хэсгийг засуулж бичүүлээрэй. (Энэ мэт байдлаар алдаатай хэсэгт засвар оруулсан хэдий ч гарын үсэг зурж, тамга дарах үүрэг хүлээхгүй)

Улмаар зөвхөн нэг хэсэг газар засвар оруулсан тохиолдолд засвар оруулаагүй бусад агуулгыг ч бас та хүлээн зөвшөөрсөнд тооцогдох тул байцаалтын тэмдэглэлд засвар оруулах үед сайтар анхаарах хэрэгтэй бөгөөд бичигдсэн агуулгын талаар бага ч гэсэн эргэлзээтэй санагдвал байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурахаас бүрэн татгалзаж өмгөөлөгчтэй зөвлөлдөхийг хүсье.

Мөн байцаалтын тэмдэглэлд засвар оруулахыг хүссэн Таны хүсэлтийг хүлээж авахгүй бол тэмдэглэлд гарын үсэг зурж тамга дарахаас эргэлзэлгүйгээр татгалзах хэрэгтэй.

8. Дуу, дүрсний бичлэг хийх үед анхаарах зүйлүүд

(1) Байцаалтын явцад дуу, дүрсний бичлэг хийсэн тохиолдолд өмгөөлөгчид мэдэгдэнэ үү

Таны байцаалтын явцыг дуу, дүрсний бичлэг хийж баталгаажуулах тохиолдол гарч болно. Байцаалтын явцыг дуу, дүрсний бичлэг хийж бэхжүүлсэн (эсвэл байцаагч дуу, дүрсний бичлэг хийх тухай Танд урьдчилан мэдэгдсэн) тохиолдолд өмгөөлөгчид заавал мэдэгдээрэй.

(2) Дуу, дүрсний бичлэг хийх үед хэрхэн хандах тухай

Дуу, дүрсний бичлэг хийх үед ч гэсэн та мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй тул мэдүүлэг өгөх эсэхийг өөрөө чөлөөтэй шийдэж болно. Хэрэв мэдүүлэг өгөхөөр нэгэнт шийдсэн бол өөрийн ой санамж, ухамсарт тулгуурлан болсон бодит байдлын (ерөнхий тойм байдал) талаар үнэн зөвөөр мэдүүлэх нь чухал. Урьд нь танаар хэргээ хүлээсэн тухай худал мэдүүлэг хүчээр өгүүлсэн бол ямар шалтгаанаар худал мэдүүлэг өгөх болсон талаар тайлбарлаарай.

Та байцаалтын явцыг дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэхийг зөвшөөрсөн ч хэрхэн мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдлэх эсэх, эсвэл мэдүүлэг өгөхийг

хүсвэл чухам юу гэж мэдүүлэх талаар өмгөөлөгчтэй урьдчилан сайтар зөвлөлдөхийг хүсье.

9. Бусад асуулт хариулт

Асуулт 1 “Прокурор”, “Цагдаагийн ажилтан” хоёр ямар ялгаатай вэ?

Хариулт 1 Цагдаагийн ажилтан Танаас болон бусад хүмүүсээс хэргийн нөхцөл байдлын талаар асууж тодруулах, хэргийн нотлох баримтыг цуглуулах зэрэг ажиллагааг явуулна. Прокурор үндсэндээ цагдаагийн ажилтантай адил хэргийн талаар асууж тодруулах, хэргийн нотлох баримтыг цуглуулах боловч Танд холбогдох гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэж буй хэргийг шүүхэд шилжүүлэх эсэх талаар шийдвэр гаргах эрхтэй байдаг.

Цагдаагийн ажилтанд Таныг шүүхэд шилжүүлэх, суллах эрх байхгүй. Хэрэв цагдаагийн ажилтан байцаалтын үед Танд “хэргийнхээ талаар мэдүүлвэл хурдан суллана” гэх мэтээр хэлсэн ч цагдаагийн ажилтанд тийм эрх байхгүй учир иймэрхүү ярианд итгэж болохгүй.

Мөн прокурорын зүгээс ч гэсэн “хэргийнхээ талаар мэдүүлвэл хурдан суллана” гэж хэлсэн ч гэсэн Таныг суллах баталгаа байхгүй учраас иймэрхүү ярианд итгэж болохгүй гэдгийг анхаарна уу.

Асуулт 2 **Хэргийн мөрдөн шалгах ажиллагаа ямар хугацаагаар үргэлжлэх вэ?**

Хариулт 2 Хэргийн мөрдөн шалгах ажиллагааны хамгийн урт хугацаа 23 хоног байна. Сэжигтнийг баривчилсаны дараа цагдан хорих эсэх талаарх шүүхийн шийдвэр гартал ихэнх тохиолдолд 1-2 хоног зарцуулах бөгөөд энэ хугацаа 3 хоногоос хэтрэхгүй. Улмаар шүүгч цагдан хорих шийдвэр гаргасан тохиолдолд эхний удаа 10 хүртэл хоног, шаардлагатай гэж үзвэл дахин 10 хүртэл хоногоор цагдан хорих хугацааг сунгадаг. Тийм болохоор цагдаа болон прокурорын байгууллагад хэргээ шалгуулж байцаалт өгөх хамгийн урт хугацаа нь 23 хоног болно.

Асуулт 3 **Хэргийн талаар сайн санахгүй байгаа тохиолдолд яах вэ?**

Хариулт 3 Санахгүй байгаа бол “санахгүй байна” гэдгээ тодорхой хэлээрэй. Та өөрөө тодорхой хэлэхгүй бол цагдаагийн ажилтан, прокурорын зүгээс “Ийм байдал болсон юм биш үү?”, “Хэрэгт хамтран оролцогч ХХХ ингэж мэдүүлж байна” гэх мэтээр тодруулах асуултуудыг асууж Танд хэргийн талаар сануулахыг оролдож магадгүй. Гэхдээ Таны ойд эргэж санах зүйл үнэхээр байхгүй бол санахгүй байгаа тань бодит үнэн учир цагдаагийн ажилтан, прокурорын тавьсан энэ төрлийн хөтөлсөн асуултад хариулах шаардлагагүй. Мэдэхгүй зүйлээ “мэдэхгүй” гэж тодорхой хэлэх хэрэгтэй. Тэгсэн хэдий ч байцаагч дахин давтан асууж, шаардаад байвал мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдлэх хэрэгтэй.

Бүлэг 4. “Сэжигтний тэмдэглэл”-ийг өдөр тутам хөтлөхийг зөвлөө

“Сэжигтний тэмдэглэл” Танд тус болно

1. Зохисгүй байдлаар байцаалт авах явдлыг хязгаарлана

Та өөрөө байцаалтын явцын талаар тэмдэглэл хөтөлснөөр байцаагчийн зохисгүй байдлаар мэдүүлэг авах оролдлогыг хязгаарлана.

2. Өмгөөлөгчид тус болно

Өмгөөлөгч тантай ганцаарчлан уулзах үед Таны бичсэн “сэжигтний тэмдэглэл”-ийг уншиж танилцсанаар хаалттай орчинд байцаалт хэрхэн явагдсан талаар төсөөлөл авахад дөхөмтэй болно.

3. Та өөрийн эрхээ ойлгож мэдэхэд ач холбогдолтой

Та өөрийн эдлэх эрх (мэдүүлэг өгөхөөс татгалзах, гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзах, байцаалтын тэмдэглэлд өөрчлөлт оруулах эрх (нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулахыг хүсэх эрх)-ээ ойлгож мэдэхэд чухал ач холбогдолтойгоос гадна,

ямар асуултад хэрхэн хариулсанаа эргэн харж дүгнэлт хийснээр дараагийн байцаалтад бэлтгэхэд хялбар болно.

4. Шүүх хурлын баримт болно

Шүүх хурал дээр мэдүүлэг өгсөн нөхцөл байдлын талаар маргаан гарсан тохиолдолд тэр талаар “сэжигтний тэмдэглэл”-д бичигдсэн байвал бодит байдлыг тогтооход дөхөмтэй болно.

5. Танд сэтгэл санааны дэмжлэг болно

Сэжигтний тэмдэглэлд мэдүүлэг өгсөн байдлаа бичиж тэмдэглэснээр байцаалтын үеийн хүнд байдлыг даван туулахад Танд сэтгэл санааны дэмжлэг болно.

Бүлэг 5. “Сэжигтний тэмдэглэл”-ийг хэрхэн хөтлөх тухай

1. Бичгийн хэрэгсэлийг худалдан авах юмуу, эсвэл хорих байрнаас түр авч хэрэглэж болно

Бичгийн хэрэгсэлийг хорих байрнаас өөрөө худалдан авч болохоос гадна түр авч хэрэглэж болно. (Сэжигтний тэмдэглэлийг бичихдээ харандаа ашиглалгүй тосон балаар бичихийг хүсье.)

2. Асуултын агуулгад хэт баригдах шаардлагагүй

Тус “сэжигтний тэмдэглэл”-д шүүхийн хэлэлцүүлэгт ашиглах зорилгоор асуултуудыг урдчилан бичсэн байгаа. Тийм учраас анкетад хариулах байдлаар бөглөж бичээрэй. Ойлгохгүй зүйл гарвал өмгөөлөгчөөс тодруулж асуугаарай.

Аль асуултад хэрхэн хариулахаа мэдэхгүй ч удаан бодож эргэлзэх шаардлагагүй. Мөн асуултын агуулгад хэт баригдах шаардлагагүй бөгөөд хоосон зай байгаа газар хаана ч хамаагүй тухайн өдрийн мэдүүлэг өгсөн байдлын талаар бичиж тэмдэглээрэй.

3. Мэдүүлэг өгсөн байдлын талаар үнэн зөв бичээрэй

“Сэжигтний тэмдэглэл”-д өөрийн өгсөн мэдүүлгийн талаар болсон байдлаар нь үнэн зөв бичээрэй. Ямар ч тохиолдолд болсон явдлыг өөрөө нэмж, хэтрүүлэгтэй бичиж болохгүй.

4. Мэдүүлгийн явцыг мартахаасаа өмнө бичиж тэмдэглээрэй

Мэдүүлэг өгсөний дараа их ядарсан байдаг боловч мэдүүлгийн явцыг мартахаасаа өмнө сайн санаж байгаа үедээ аль болох хурдан бичиж тэмдэглээрэй. Мэдүүлэг өгсөн тэр өдөртөө тэмдэглэж амжихгүй бол маргааш нь заавал бичээрэй.

5. Хуудас бүрд тэмдэглэл бичсэн огноог зөв бичиж, гарын үсгээ зураарай

“Сэжигтний тэмдэглэл” нь 1 өдрийн мэдүүлгийг 2 дэлгэмэл хуудсанд бичихээр хэвлэгдсэн байгаа. “1 өдрийн мэдүүлэг”-ийг тэмдэглэж дууссаны дараа баруун талын доод хэсэгт байгаа огноо бичих хэсэгт “тэмдэглэл бичсэн огноо” (Мэдүүлэг өгсөн огнооноос өөр өдөр байх тохиолдол гарч болно)-г бичээрэй. “Тэмдэглэл бичсэн огноо”-г бичсэнээс хойш тэр хуудсанд ямар нэг зүйл нэмж бичиж болохгүй. Энэ нь тэмдэглэлийн агуулгад дараа нь өөрчлөлт оруулсан гэсэн шүүмжлэл үүсэхээс сэргийлэх зорилготой юм.

Хэрэв тухайн өдрийн мэдүүлгийн талаар дараа эргэж санасан зүйл гарвал, эргэж санасан тэр өдрийнхөө тэмдэглэлд “хх сарын хх өдрийн мэдүүлгийн үед хххх гэсэн явдал болсоныг эргэж саналаа” гэх маягаар бичээрэй.

Бүлэг 6. “Сэжигтний тэмдэглэл”-ийг хэрхэн ашиглах тухай

1. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах үед авч ирээрэй

Сэжигтний тэмдэглэлийг өмгөөлөгчтэй уулзах үед уулзалтын өрөөнд авч ирэн өмгөөлөгчид үзүүлж мэдүүлэг өгсөн байдлаа танилцуулна уу.

2. Дараагийн өдөр өмгөөлөгчид түр буцааж өгөөрэй

“Сэжигтний тэмдэглэл”-ийг өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаанд ашиглахын тулд танаар тэмдэглэл хөтлүүлж байгаа тул дараа өдөр өмгөөлөгчид түр буцааж өгнө үү.

Бүлэг 7. Хууль бус, зохисгүй байдлаар байцаалт авсан тохиолдолд яах вэ?

1. Хууль бус, зохисгүй байдлаар мэдүүлэг авсан үед

Хэрэв Танаас хууль бус, зохисгүй байдлаар байцаалт авсан бол нэн даруй өмгөөлөгчөө дуудаж мэдэгдэхийг хүсье. Өмгөөлөгч Таны байр сууринаас эрх ашгийг тань хамгаалахын төлөө ажиллана. Та өмгөөлөгчтэй зөвлөлдсөнөөр өмгөөлөгч, цагдаа болон прокурорын үйл ажиллагааны талаар эсэргүүцэл илэрхийлэх зэргээр Таны хууль ёсны эрх ашгийг бүрэн хамгаалахын төлөө өмгөөллийн ажиллагааг явуулах болно.

Мөн мэдүүлэг өгөх ажиллагаатай холбогдсон гомдол гаргах журмын талаар доор бичсэн тул уншиж танилцахыг хүсье. “Сэжигтний тэмдэглэл”-д мэдүүлэг өгсөн байдлын талаар бичихдээ тодорхой, болсон байдлаар нь үнэн зөв бичиж тэмдэглээрэй.

2. Цагдаагийн ажилтны талаар гомдол гаргах

“Сэжигтнээс байцаалт авах ажиллагааг зөв зохистой хэрэгжүүлэх талаар хяналт тавих тухай журам”-д доорх 7 үйлдлийг зохисгүй үйлдэл гэж заасан байна. Мөн тэдгээр зохисгүй үйлдлийг байцаалтын ажиллагааны хяналт хариуцсан ажилтан шалган тодруулсан бол байцаалт явуулах ажиллагааг зогсоохыг шаардаж болно гэж заасан байдаг. Улмаар цагдаагийн ажилтан байцаалт авах ажиллагаатай холбогдсон гомдол хүлээж авсан тохиолдолд нэн даруй байцаалтын ажиллагааны хяналт хариуцсан ажилтанд мэдээлэх үүрэгтэй бөгөөд “зохисгүй үйлдэл” явагдсан хангалттай үндэслэл байна гэж үзвэл харьяа цагдаагийн газрын дарга хяналтын байцаагчийг томилж “зохисгүй үйлдэл” явагдсан эсэх талаар шалгалт хийнэ гэж заасан байна.

- (1) Зайлшгүй нөхцөл байдлаас бусад үед сэжигтний биед хүрэх
- (2) Шууд болон шууд бус байдлаар биеийн хүч хэрэглэх (Дээрх (1)-д зааснаас бусад тохиолдолд)
- (3) Сэжигтэнд санаатайгаар айдас төрүүлэх, хүнд байдалд оруулах утга

бүхий үг хэллэг хэрэглэх, үйлдэл гаргах

- (4) Байнга нэг хэлбэрийн биеийн байдалд байх, эсвэл тодорхой нэг хөдөлгөөн үргэлжлүүлэн хийхийг зохисгүй байдлаар шаардах
- (5) Сэжигтний ямар нэг дур сонирхол, хүсэлтийг хангах, эсвэл тэр байдлыг хангах талаар санал болгох, амлах
- (6) Хүний нэр төрийг ноцтойгоор гутаан доромжилсон үг хэллэг хэрэглэх, үйлдэл гаргах
- (7) Дараах тохиолдлуудад Токио хотын цагдаагийн газрын дарга, харьяа мужийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн тусгай ангийн дарга, цагдаагийн хэлтсийн даргын зөвшөөрлийг урьдчилан авна
 - а. Оройн 10 цагаас дараа өдрийн өглөөний 5 цагийн хооронд сэжигтнээс мэдүүлэг авах
 - б. Өдөрт 8 цагаас илүү хугацаагаар сэжигтнээс мэдүүлэг авах

Дээр бичигдээгүй бусад үйлдлийн талаар ч гомдол гаргаж болох тул өмгөөлөгчөөс зөвлөгөө аваарай.

3. Прокурорын талаар гомдол гаргах

Прокурорын Ерөнхий газраас прокурорын авсан байцаалтын талаар “Байцаалт авах ажиллагаатай холбогдсон гомдлын талаар мэдээлэл авах болон гомдлыг барагдуулах тухай” удирдамж гаргасан байгаа бөгөөд прокурорын авсан байцаалттай холбоотойгоор сэжигтэн болон түүний өмгөөлөгчөөс гаргасан гомдлыг шийдвэрлэх талаар заасан байдаг.

Төгсгөл

Таны өөрийн тань сэтгэлийн тэвчээр хамгийн чухал

Байцаалтад хэрхэн бэлтгэх талаар болон Таны хууль ёсны эрхийн талаар танилцууллаа. Та мэдүүлэг өгөхөөс татгалзах (бүлэг 3-ын 2-ыг үзнэ үү), байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзах (бүлэг 3-ын 5-ыг үзнэ үү), мөн байцаалтын тэмдэглэлд нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулахыг хүсэх эрхтэй (бүлэг 3-ын 7-г үзнэ үү) .

Хэдийгээр дээрх эрхүүдийг эдлэх эрхтэй гэдгээ та мэдэж байгаа хэдий ч, бодитоор хэрэгжүүлэх нь тийм ч хялбар биш. Ер нь тухайн байцаалтын цагийг дуустал мэдүүлэг өгөхөөс татгалзаж дуугүй байх боломжгүй. Мөн байцаагчийн зүгээс байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, тамга дарахыг тулган шаардсан нөхцөл байдалд гарын үсэг зурж, тамга дарахаас удаан хугацааны туршид татгалзах нь маш хэцүү.

Та байцаалтын тэмдэглэлд өөрчлөлт оруулах хүсэлт тавьсан үед агуулгын хувьд ач холбогдол бага газарт засвар оруулж өгөх боловч Таны хэрэгт маш чухал ач холбогдолтой мэдүүлгийн хэсгийг тийм амар засаж өгөхгүй.

Байцаалтын үед байцаагчийн хэлж ярьсаныг дагахгүй бол Таныг элдвээр шүүмжилж, төрөл бүрийн дарамт шахалт үзүүлэх байдал ч гардаг. Ийм байдалд 23 хоногийн турш, өдөрт олон цагаар мэдүүлэг өгөх болно.

Гэтэл өмгөөлөгчтэй уулзах уулзалтын хувьд ямар ч хүнд хэрэг байсан өдөрт 1 удаа, ойролцоогоор 1 цаг орчим уулзана. Та өмгөөлөгчтэй байлаа ч гэсэн байцаалтын үед өмгөөлөгч байлцахыг зөвшөөрөхгүй байгаа өнөөгийн нөхцөлд та эрхээ хэрэгжүүлэх нь туйлын хэцүү. Дээрх зөвлөгөөг нэг удаа уншаад дуусах нь хангалтгүй тул олон удаа уншаарай.

Нэг сэжигтэн өглөө бүр өөрийн бичсэн байцаалтын тэмдэглэл болон “сэжигтний тэмдэглэл”-д бичигдсэн бусад зөвлөгөөг дахин нэг уншсаны дараа мэдүүлэг өгдөг байсан.

Гэвч түүний өөрийнх нь мэдүүлсэн зүйлийг байцаагч байцаалтын тэмдэглэлд бичиж өгөхгүй байсан тул тухайн өдрийн мэдүүлэг дуусахад маш их ядарсанаа мэдэрдэг

байсан гэж тэрээр ярьж байсан.

Байцаалтын бүх явцыг дүрс бичлэгээр бэхжүүлэх (байцаалтын явцыг нээлттэй болгох) ажиллагаа хэрэгжиж эхэлвэл сэжигтнээс зохисгүй байдлаар мэдүүлэг авах явдал буурах байх. Зохисгүй байдлаар мэдүүлэг авсан ч дараа нь шалгаж тодруулах боломжтой болно. Өмгөөлөгчдийн зүгээс байцаалтын явцыг нээлттэй болгохыг шаардаж байгаа боловч мөрдөн шалгах байгууллага энэ шаардлагыг хүлээн авч хэрэгжүүлэхгүй байна. (Байцаалтын хэсэгчилсэн бичлэг хийхийг зөвшөөрч байгаа боловч энэ нь байцаалтын явцыг нээлттэй болгохоос эрс ялгаатай).

Тийм учраас Та өөрөө эрхээ хэрэгжүүлэх нь тийм ч хялбар зүйл биш гэдгийг сайтар ойлгож, өөрт олгогдсон эрхээ оновчтой зөв хэрэгжүүлэн, байцаалтын явцад тулгарах хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах нь хамгийн чухал.

Мэдээж өмгөөлөгч Таныг дэмжиж ажиллах боловч Таны өөрийн тань сэтгэлийн тэвчээр юунаас ч илүү чухал болно.

Мэдүүлэг өгсөн тэмдэглэл

取調日(年/月/日)

1. Мэдүүлэг өгсөн огноо (он/сар/өдөр) _____ / _____ / _____

時間

開始時間

終了時間

Цаг:

ЭХЭЛСЭН

:

ДУУССАН

:

:

:

:

:

場所

警察署

検察庁

Газар

Цагдаагийн хэлтэс

Прокурорын газар

取調官(警察官, 検察官)の氏名

Байцаагчийн овог, нэр (цагдаагийн ажилтан / прокурор)

(1)

(2)

取調べについて

2. Мэдүүлэг өгсөн байдал

黙秘権の告知はありましたか

なし

覚えていない

あり

(1) Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг танилцуулсан уу? * 2

Үгүй

Санахгүй байна

Тийм

録画はなされましたか

なし

あり

(2) Дүрс бичлэг хийсэн үү?

Үгүй

Тийм

暴行や脅迫はありましたか

なし

あり

(3) Хүч хэрэглэсэн, эсвэл айлган сүрдүүлсэн үү?

Үгүй

Тийм

(3)が有る場合)具体的に書いてください

(3)-д бичигдсэн үйлдэл болсон бол тодорхой бичнэ үү. _____

印象に残った取調官の言葉等があれば書いてください

(4) Байцаагчаас онцолж асуусан асуулт зэрэг онцгой сэтгэгдэл төрүүлсэн зүйл байвал бичнэ үү.

弁護人について何か言われたことがあれば書いてください

(5) Байцаагч Таны өмгөөлөгчийн талаар ямар нэг зүйл хэлсэн бол бичнэ үү.

通訳について

3. Хэлмэрчийн талаар

通訳人の通訳する言葉は分かりましたか

Та хэлмэрчийн яриаг ойлгосон уу?

分かった

分からないところがあった

分からなかった

Ойлгосон

Ойлгохгүй зүйл байсан

Ойлгоогүй

取調事項について

4. Мэдүүлгийн агуулгын талаар

どのような事項について取調べを受けましたか

身上関係

動機

(1) Мэдүүлгийн үед юуны тухай асуусан бэ?

Биеийн байцаалт, намтар

Хэргийн сэдэлт

犯行状況

共犯関係

その他

Хэрэг үйлдсэн байдал

Хэрэг хамтран

Бусад зүйл

具体的に書いてください

(2) Дэлгэрэнгүй бичнэ үү.

あなたの対応について

5. Таны өгсөн мэдүүлгийн агуулга болон байцаалтад хэрхэн хандсан талаар

- あなたはどのような供述をしましたか 黙秘 否認 一部否認 自白
- (1) Хэрхэн мэдүүлсэн Мэдүүлэг өгөхөөс татгалзсан Бүрэн үгүйсгэсэн Хэсэгчлэн үгүйсгэсэн Хэргээ хүлээсэн
- 具体的に書いてください
- (2) Хэрхэн мэдүүлсэн талаар дэлгэрэнгүй бичнэ үү.

供述調書について

6. Байцаалтын тэмдэглэлийн талаар

- 取調官は調書の文面を作成しましたか
- (1) Байцаагч байцаалтын тэмдэглэл үйлдсэн үү?
- メモのみ 作成終了
- Зөвхөн гар тэмдэглэл үйлдсэн Байцаалтын тэмдэглэл үйлдсэн
- 調書の読み聞かせはありましたか なし あり
- (2) Байцаалтын тэмдэглэлийг уншиж өгсөн үү? Үгүй Тийм
- あなたが供述したとおりに調書は作成されましたか
- (3) Таны мэдүүлсэний дагуу үнэн зөв бичигдсэн үү?
- 供述のとおりではない 分からない 供述のとおりだと思う
- Үгүй Мэдэхгүй Мэдүүлсэний дагуу
- 訂正の申入れをしましたか
- (4) Байцаалтын тэмдэглэлд засвар оруулахыг хүссэн үү? (*3)
- 訂正に応じてくれない 申し入れていない 訂正に応じた
- Засаж өгөөгүй Засуулахыг хүссээгүй Засаж өгсөн
- 調書への署名をしましたか?
- (5) Байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурсан уу? (*4) Татгалзсан Тийм

取調べについてあなたが思ったこと、感じたことを書いてください

7. Байцаалтын талаар бодож санасан, сэтгэлд үлдсэн зүйлийн талаар бичнэ үү.

弁護人はあなたの正当な権利利益を守る立場で活動します。また、守秘義務がありますから、秘密が漏れることはありません。

*1 Өмгөөлөгч таны эрх, ашиг сонирхолыг хамгаалан ажиллана. Мөн хувийн нууцыг хадгалах үүрэгтэй тул Таны нууцыг задруулахгүй.

黙秘権が保障されていますので、取調官から供述を迫られても供述を拒否できます(憲法第38条第1項)。

*2 Байцаагч мэдүүлэг өгөхийг шаардсан ч Та мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй (Үндсэн хуулийн 38-р зүйлийн 1 дэх хэсэг)

あなたは供述調書の記載内容を訂正するよう求めることができます(刑事訴訟法第198条第4項)。

*3 Та байцаалтын тэмдэглэлд засвар оруулахыг хүсэх эрхтэй. (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 198-р зүйлийн 4 дэх хэсэг)

供述調書に署名押印することは義務ではありません。内容の正誤・理由にかかわらず、拒否できます(刑事訴訟法第198条第5項)。

*4 Байцаалтын тэмдэглэлд гарын үсэг зурж, тамга дарах тухай хуулиар хүлээсэн үүрэг танд байхгүй. Бичигдсэн зүйлийн агуулга зөв бичигдсэн эсэхээс үл хамааран Та гарын үсэг зурж, тамга дарахаас татгалзах эрхтэй. (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 198-р зүйлийн 5 дахь хэсэг)

作成日: 年 / 月 / 日

署名

Тэмдэглэл бичсэн он / сар / өдөр (он / сар / өдөр)

Гарын үсэг

/ /

Мэдүүлэг өгсөн тэмдэглэл

取調日(年/月/日)

1. Мэдүүлэг өгсөн огноо (он/сар/өдөр) _____ / _____ / _____

時間 開始時間 終了時間
Цаг: ЭХЭЛСЭН : Дууссан :

場所 警察署 検察庁
Газар Цагдаагийн хэлтэс Прокурорын газар

取調官(警察官, 検察官)の氏名
Байцаагчийн овог, нэр (цагдаагийн ажилтан / прокурор)
(1) _____ (2) _____

取調べについて

2. Мэдүүлэг өгсөн байдал

黙秘権の告知はありましたか なし 覚えていない あり
(1) Мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг танилцуулсан уу? * 2 Үгүй Санахгүй байна Тийм
録画はなされましたか なし あり
(2) Дүрс бичлэг хийсэн үү? Үгүй Тийм
暴行や脅迫はありましたか なし あり
(3) Хүч хэрэглэсэн, эсвэл айлган сүрдүүлсэн үү? Үгүй Тийм
(3)が(ありの場合)具体的に書いてください
(3)-д бичигдсэн үйлдэл болсон бол тодорхой бичнэ үү. _____
印象に残った取調官の言葉等があれば書いてください
